

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/184/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichko.0808@gmail.com

Хаан Соёмбо Аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Аудитын менежер Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/ддт
танай _____-ны № _____-т

РАШААНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Н.АМАРЖАРГАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 53,029.4 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 40,957.0 мянган төгрөгийн эмийн шууд худалдан авалт хийсэн, нийгмийн эрүүл мэндийн зардлаас 1,040.0 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 3 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>178,817,317.40</u>	<u>173,502,562.56</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	53,029,453.62
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	53,029,453.62
3121	Төгрөг	00.00	53,029,453.62
31211	Төрийн сангийн харилцах	00.00	53,029,453.62
33	АВЛАГА	81,034,935.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	59,818,100.00	00.00
335	Бусад авлага	21,216,835.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	21,216,835.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	97,782,382.40	120,473,108.94
351	Түүхий эд материал	32,642,950.70	35,898,605.63
35130	Эм боох материал	32,642,950.70	35,898,605.63
354	Хангамжийн материал	65,139,431.70	84,574,503.31
35410	Бичиг хэргийн материал	670,000.00	806,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,846,000.00	00.00
35460	Хүнсний материал	491,665.00	5,876,835.00
35470	Бусад хангамжийн материал	59,131,766.70	77,891,668.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>448,995,021.62</u>	<u>465,640,468.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	448,995,021.62	465,640,468.43
392	Биет хөрөнгө	436,733,521.62	453,514,801.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	354,952,789.00	354,952,789.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30,088,996.16	-40,041,994.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,544,444.00	42,284,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,790,894.60	-24,735,944.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	99,695,656.26	139,901,704.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,334,777.83	-39,586,779.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,998,742.00	23,862,042.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,368,440.93	-9,621,014.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,000,000.00	13,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,875,000.12	-6,500,000.16
393	Биет бус хөрөнгө	12,261,500.00	12,125,666.60
39301	Програм хангамж	407,500.00	407,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-135,833.40
39303	Бусад биет бус хөрөнгө	11,854,000.00	11,854,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>627,812,339.02</u>	<u>639,143,030.99</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>627,812,339.02</u>	<u>639,143,030.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	627,812,339.02	639,143,030.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	243,416,874.00	243,416,874.00
512	Хуримтлагдсан үр дүн	122,958,129.36	134,288,821.33
51210	Өмнөх үеийн үр дүн	122,958,129.36	122,958,129.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	11,330,691.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,437,335.66	261,437,335.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>627,812,339.02</u>	<u>639,143,030.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,045,949,071.18	763,765,892.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	340,732,506.18	101,833,272.14
120	Нийтлэг татварын бус орлого	323,198,806.18	101,833,272.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	323,198,806.18	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	323,198,806.18	00.00
122	Тусламжийн орлого	17,533,700.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	17,533,700.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,833,465.00	661,932,620.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	396,383,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	241,363,775.00	659,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,091,100.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,204,675.00	659,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,249,900.00	00.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,826,000.00	41,401,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,826,000.00	41,401,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,643,690.00	619,871,920.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,643,690.00	619,871,920.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	902,806,575.90	751,959,891.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,806,575.90	751,959,891.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,006,575.90	751,959,891.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,588,100.00	405,679,918.29
210101	Үндсэн цалин	211,627,494.31	261,932,938.71
210102	Нэмэгдэл	78,827,105.69	106,086,645.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	3,241,815.58
210104	Урамшуулал	62,978,500.00	32,823,028.70
210105	Гэрээт ажлын хөлс	3,555,000.00	1,595,490.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,627,950.00	49,421,388.79
210201	Тэтгэврийн даатгал	34,125,950.00	34,107,147.80
210202	Тэтгэмжийн даатгал	3,341,340.00	3,863,809.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,983,400.00	3,091,047.34
210204	Ажилгүйдлийн даатгал	926,160.00	759,944.10
210205	Эрүүл мэндийн даатгал	7,251,100.00	7,599,440.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,282,400.00	30,240,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,260,400.00	2,440,000.00
210302	Түлш, халаалт	25,042,000.00	25,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,980,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,783,426.00	42,540,364.00
210401	Бичиг хэрэг	2,861,000.00	2,585,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,827,825.00	26,065,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,679,300.00	3,069,500.00
210404	Ном, хэвлэл	61,800.00	00.00

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,820,000.00	2,705,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,533,501.00	8,115,664.00
2105	Нормативт зардал	346,451,462.54	129,090,031.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	330,614,697.54	113,866,026.30
210502	Хоол, хүнс	10,369,735.00	11,371,505.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,467,030.00	3,852,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,462,329.40	33,984,896.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,314,729.40	8,854,896.60
210604	Урсгал засвар	3,147,600.00	25,130,000.00
2107	Томилолт, зочны зардал	856,200.00	1,653,200.00
210702	Дотоод албан томилолт	856,200.00	1,653,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,756,300.00	8,968,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	5,087,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,040,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,400.00	66,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	45,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,600.00	37,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	313,500.00
210807	Газрын төлбөр	118,600.00	120,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,091,200.00	2,258,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,198,407.96	50,381,792.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,583,500.00	8,849,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,614,907.96	41,532,592.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,800,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,800,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,800,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>143,142,495.28</u>	<u>11,806,000.73</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,000,000.00	475,308.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,000,000.00	475,308.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,000,000.00	-475,308.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>128,142,495.28</u>	<u>11,330,691.97</u>

СТ-3А

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>645,398,465.00</u>	<u>721,750,720.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>645,398,465.00</u>	<u>721,750,720.00</u>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	396,383,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	181,545,675.00	659,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,662,375.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,805,400.00	659,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,826,000.00	41,401,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,826,000.00	41,401,700.00

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,643,690.00	679,690,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,643,690.00	679,690,020.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	639,418,465.00	657,341,266.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	639,418,465.00	657,341,266.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,618,465.00	657,341,266.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,588,100.00	405,679,918.29
210101	Үндсэн цалин	211,627,494.31	261,932,938.71
210102	Нэмэгдэл	78,827,105.69	106,086,645.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	3,241,815.58
210104	Урамшуулал	62,978,500.00	32,823,028.70
210105	Гэрээт ажлын хөлс	3,555,000.00	1,595,490.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,627,950.00	49,421,388.79
210201	Тэтгэврийн даатгал	34,125,950.00	34,107,147.80
210202	Тэтгэмжийн даатгал	3,341,340.00	3,863,809.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,983,400.00	3,091,047.34
210204	Ажилгүйдлийн даатгал	926,160.00	759,944.10
210205	Эрүүл мэндийн даатгал	7,251,100.00	7,599,440.20
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,832,400.00	30,240,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,260,400.00	2,440,000.00
210302	Түлш, халаалт	24,592,000.00	25,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,980,000.00	2,000,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,389,625.00	50,130,100.00
210401	Бичиг хэрэг	2,861,000.00	2,550,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,827,825.00	26,065,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,679,300.00	3,069,500.00
210404	Ном, хэвлэл	226,800.00	96,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,820,000.00	5,103,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,974,700.00	13,246,000.00
2105	Нормативт зардал	118,232,290.00	76,831,659.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,937,290.00	53,274,984.30
210502	Хоол, хүнс	8,452,400.00	16,756,675.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,842,600.00	6,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,873,600.00	23,867,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	880,000.00	165,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,856,500.00
210604	Урсгал засвар	7,993,600.00	21,846,000.00
2107	Томилолт, зочны зардал	856,200.00	1,653,200.00
210702	Дотоод албан томилолт	856,200.00	1,653,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,756,300.00	8,968,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	5,087,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,040,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,400.00	66,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	45,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,600.00	37,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	313,500.00
210807	Газрын төлбөр	118,600.00	120,000.00

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,091,200.00	2,258,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,462,000.00	10,549,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,462,000.00	10,549,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,800,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,800,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,800,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,980,000.00	64,409,453.62
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,980,000.00	11,380,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,980,000.00	11,380,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,980,000.00	11,380,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,980,000.00	11,380,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,980,000.00	-11,380,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	53,029,453.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	53,029,453.62

СТ-4А

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	-10,619,808.26	494,234,401.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	-10,619,808.26	494,234,401.40
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	128,142,495.28	128,142,495.28
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	122,958,129.36	627,812,339.02
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	122,958,129.36	627,812,339.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	122,958,129.36	627,812,339.02
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,330,691.97	11,330,691.97
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	134,288,821.33	639,143,030.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	720,822,200.00	668,721,266.38	52,100,933.62	92.77
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	720,822,200.00	668,721,266.38	52,100,933.62	92.77
210	Бараа, үйлчилгээний зардал	720,822,200.00	668,721,266.38	52,100,933.62	92.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,458,000.00	405,679,918.29	23,778,081.71	94.46

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	262,786,000.00	261,932,938.71	853,061.29	99.68
210102	Нэмэгдэл	108,969,500.00	106,086,645.30	2,882,854.70	97.35
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	7,150,000.00	3,241,815.58	3,908,184.42	45.34
210104	Урамшуулал	49,071,000.00	32,823,028.70	16,247,971.30	66.89
210105	Гэрээт ажлын хөлс	1,481,500.00	1,595,490.00	(113,990.00)	107.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,922,300.00	49,421,388.79	500,911.21	99.00
210201	Тэтгэврийн даатгал	34,605,500.00	34,107,147.80	498,352.20	98.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,829,200.00	3,863,809.35	(34,609.35)	100.90
210203	ҮОМШӨ ний даатгал	3,063,400.00	3,091,047.34	(27,647.34)	100.90
210204	Ажилгүйдлийн даатгал	765,800.00	759,944.10	5,855.90	99.24
210205	Эрүүл мэндийн даатгал	7,658,400.00	7,599,440.20	58,959.80	99.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,240,000.00	30,240,000.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	2,440,000.00	2,440,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	25,800,000.00	25,800,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,130,100.00	50,130,100.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	2,550,000.00	2,550,000.00	-	100.00
210402	Тээвэр (шатахуун)	26,065,000.00	26,065,000.00	-	100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,069,500.00	3,069,500.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	96,000.00	96,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,103,600.00	5,103,600.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	13,246,000.00	13,246,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	104,138,600.00	76,831,659.30	27,306,940.70	73.78
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	78,122,100.00	53,274,984.30	24,847,115.70	68.19
210502	Хоол, хүнс	19,216,500.00	16,756,675.00	2,459,825.00	87.20
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	6,800,000.00	6,800,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	35,247,500.00	35,247,500.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,545,000.00	11,545,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,856,500.00	1,856,500.00	-	100.00
210604	Урсгал засвар	21,846,000.00	21,846,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,889,700.00	1,653,200.00	236,500.00	87.48
210702	Дотоод албан томилолт	1,889,700.00	1,653,200.00	236,500.00	87.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,246,800.00	8,968,300.00	278,500.00	96.99

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,366,000.00	5,087,500.00	278,500.00	94.81
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,040,000.00	1,040,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	66,000.00	66,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,600.00	45,600.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	37,200.00	37,200.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	313,500.00	313,500.00	-	100.00
210807	Газрын төлбөр	120,000.00	120,000.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,258,500.00	2,258,500.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	10,549,200.00	10,549,200.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,549,200.00	10,549,200.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	723,179,800.00	721,750,720.00	1,429,080.00	99.80
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,401,700.00	41,401,700.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	41,401,700.00	41,401,700.00	-	100.00
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	681,119,100.00	679,690,020.00	1,429,080.00	99.79
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	681,119,100.00	679,690,020.00	1,429,080.00	99.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	659,000.00	659,000.00	-	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	659,000.00	659,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	53,029,453.62	(53,029,453.62)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Рашаант сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 09-ны өдрийн А/03 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 4 зүйл 11 заалтын хүрээнд хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

¹ “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

² “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Рашаант сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,330.7 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	53,029.5	53,029.5
Авлага	81,034.9	0	-81,034.9
Бараа материал	97,782.4	120,473.1	22,690.8
Үндсэн хөрөнгө	448,995.0	465,640.5	16,645.4
Нийт хөрөнгө	627,812.3	639,143.0	11,330.7
Өр төлбөр		0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	627,812.3	639,143.0	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	627,812.3	639,143.0	11,330.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 53,029.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 22,690.8 мянган төгрөгөөр өссөн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусийн үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байгаа нь гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 16,645.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 58,653.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 11,380.0 мянган төгрөг, 47,273.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй буюу улсын төсөв, орон нутгийн төсвөөс ирсэн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 678,890.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 659.0 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 41,401.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна. Нийт зарлагыг 668,364.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хангамж бараа материалын зардлыг 25,400.0 мянган төгрөгөөр бууруулж, 720,822.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тээвэр шатахууны зардлыг 15,500.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардлыг 3,200.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардлыг 5,500.0 мянган төгрөг, шуудан холбоо интернэтийн зардлыг 1,200.0 мянган төгрөгөөр илүү тооцоолсон байна. Энэ нь 2022 төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2022 оны эхэнд 42,200.0 төгрөг орон нутгийн төсвөөс батлагдсанаас 1,200.0 мянган төгрөг хасах тодотгол хийгдэж 41,401.7 мянган төгрөг болсон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 720822.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр, 41,401.7 мянган төгрөгийг Орон нутгийн урсгал санхүүжилтээс үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 679,690.0 мянган төгрөг, Орон нутгийн орлогоос 41,401.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 53,029.4 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 668,721.3 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 52,100.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	367,409.6	347,112.1	20,297.5	94.5%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	231,793.8	199,990.4	31,803.4	86.3%

3	Дээд шатны төсвөөс хувиарласан	80,217.1	80,217.1	0	100%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	37,926.0	37,926.0	0	100%
5	Нийтлэг үйлчилгээ	3,475.7	3,475.7	0	100%
	ДҮН ТАВИАРАЙ	720822.2	668721.3	52100.3	92.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 81,034.9 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, Аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 902,806.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 18,056.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томиллолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага,

төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй гүйлгээ байхгүй, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй гүйлгээ байхгүй ба орлогын зөрүүтэй мэдээлсэн дүн 5,180.2 мянган төгрөгийн 1 гүйлгээ мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн тул аудитаар зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага байхгүй, Шилэн данс, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл улсын бүртгэлийн гэрчилгээний дүнтэй зөрүүтэй, эмийн авлага үүссэн гэсэн 3 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг ханган биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	81,000.0	3	81,000.0	100
Нийт дүн	3	81,000.0	3	81,000.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 40,957.0 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 116,419.1 мянган төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 65,101.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 51,317.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 59,818.1 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 5,283.6 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 51,317.4 мянган төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 51,317.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас 1,040.0 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е-баримт/ баримтгүй 45,097.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй гүйлгээ байхгүй, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй гүйлгээ байхгүй ба орлогын зөрүүтэй

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэдээлсэн дүн 5,180.2 мянган төгрөгийн 1 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 202 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	59,818.1			1	59,818.1	1	59,818.1				
Эдийн засгийн ангилал зөрүүтэй	1	5,283.6			1	5,283.6	1	5,283.6				
Дүн	2	65,101.7			2	65,101.7	2	65,101.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зориулалтаар нь зарцуулаагүй	1	1,040.0					1	1,040.0				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	45,097.2					1	45,097.2				
Дүн	2	46,137.2					2	46,137.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ зөрүүтэй мэдээлсэн	1	5,180.2						1	5,180.2
Дүн	1	5,180.2						1	5,180.2

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

